



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААН,
ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СУРГУУЛЬ

14201 Улаанбаатар хот-46а ш/х-600
Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж 3,
Утас: 32-56-31, Факс: (976-11) 32-56-31,
И-мэйл: dean@seas.num.edu.mn, Вэб: http://seas.num.edu.mn

2017.10.27 № 10 м/527
танай _____-ны № _____-т

“Эрдэм шинжилгээний хурал
зохион байгуулах тухай”

Энэ хичээлийн жилд Монгол Улсын Их Сургууль үүсэн байгуулагдсаны 75 жил, үндэсний дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэж эхэлсний 75 жил, математикийн салбар үүсч хөгжсөний 75 жил, цаг уур, ус судлалын салбар үүсч хөгжсөний 55 жилийн түүхэн тэмдэглэлт ой тохиож байгаа билээ.

Төрөлх сургуулийнхаа энэхүү баярыг сургууль, тэнхимийн зүгээс сургалт, эрдэм шинжилгээ, бүтээн байгуулалтын амжилт арвинтай угтаж байна. МУИС шинэ номын сангийн нээлтээ хийгээд удаагүй байгаа баяртай энэ цаг мөчид хэрэглээний математикийн тэнхимийн хамт олон дифференциал–интеграл тооллын сурах бичгийн орчуулгыг саяхан өлгийдөн авлаа.

Ойн арга хэмжээг өргөн цар хүрээтэй тэмдэглэх, хэрэглээний математикийн ухааны ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, онол практикийн асуудлуудыг дэвшүүлэх, эдийн засаг, инженерчлэл, нийгэм, банк санхүү, даатгал, байгаль орчин, хөдөө аж ахуй, ус, цаг уур зэрэг бусад салбаруудад тулгарч байгаа болон тулгарч болох математик арга, аргачлал, шийдлүүдийг таниулж сурталчилах, туршлагаа солилцох харилцан үр ашигтайгаар хамтран ажиллах, хамтран ажиллах зорилготойгоор Хэрэглээний Математикийн Тэнхимээс эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж байна.

“Хэрэглээний математик-2017” эрдэм шинжилгээний анхдугаар хурал 2017 оны 11 дүгээр сарын 25-нд Монгол Улсын Их Сургуулийн Номын санд болох тул албан байгууллага, судлаач нарыг өргөнөөр оролцохыг урьж байна.
Холбоо барих утас: 99182806, 85694213

Жич: 11 дүгээр сарын 05-ны өдрөөс өмнө эрдэм шинжилгээний хуралд оролцох албан байгууллага, судлаач нар мэдүүлгээ ирүүлнэ үү. Хурлын удирдамжийг хавсралтаар хүргүүлэв.

ТЭНХИМИЙН ЭРХЛЭГЧ



Б.БАРСБОЛД

My.Doc.2017.Alban bichig



“ХЭРЭГЛЭЭНИЙ МАТЕМАТИК 2017” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ

Хурлын зохион байгуулалт: Хурал 2017 оны 11-р сарын 25-ны өдөр МУИС-ын Төв номын санд 10-18 цагийн хооронд болно. Хурлыг нэгдсэн ба салбар хуралдаанаар зохион байгуулна.

Зохион байгуулагч: МУИС-ХШУИС- Хэрэглээний математикийн тэнхим

Хурлын зорилго: Хэрэглээний математикийн ухааны хөгжлийн чиг хандлага, онол практикийн асуудлууд, эдийн засаг, инженерчлэл, нийгэм, банк санхүү, даатгал, байгаль орчин, хөдөө аж ахуй, ус, цаг уур зэрэг бусад салбаруудад тулгарч байгаа болон тулгарч болох математик асуудлуудыг тодорхойлох, арга туршлагаа солилцох хамтран үр ашигтайгаар шийдвэрлэх, хамтран ажиллахад энэ хурлын ач холбогдол оршино.

Хамрах хүрээ (хэлэлцэх асуудлын чиглэлүүд):

- Тооцон бодох математик
- Дифференциал тэгшитгэл, тухайн уламжлалт дифференциал тэгшитгэл
- Оновчлол, оновчтой удирдлага
- Санхүүгийн математик, даатгалын математик, эрсдлийн шинжилгээ
- Цаг уур
- Ус судлал
- Хүрээлэн буй орчин судлал
- Уур амьсгал судлал
- Экологи, байгаль хамгаалал
- Мэдээлэлийн технологи
- Инженерчлэл
- Боловсрол судлал
- Хөдөө аж ахуй
- Логистик, үйлдлийн шинжилгээ
- Аж үйлдвэрийн математик

Хуралдаанд оролцогч нь дараах хэлбэрээр оролцож болно.

- Илтгэл хэлэлцүүлж хэвлүүлэх
- Постер илтгэл хэлэлцүүлж хэвлүүлэх
- Зөвхөн хурлын эмхэтгэлд хэвлүүлэх

Хугацааны тов:

- Мэдүүлэг, эрдэм шинжилгээний өгүүлэл хүлээн авах **2017-11-05**
- Хурлын программ хэвлэх **2017-11-12**
- Хурал болох **2017-11-25-ны Бямба гараг**

Бүртгэлийн хураамж 1 оролцогч 60 000₮.

Хуралд оролцогчийн мэдүүлгийг <http://seas.num.edu.mn/dep/am/files> хаягаас татаж аваад, дараах талбаруудыг бүрэн бөглөөд зохион байгуулагчид batbileg@seas.num.edu.mn хаягаар илгээнэ үү.

1. Илтгэл/өгүүллийн нэр
2. Зохиогчийн овог нэр, цол зэрэг, албан тушаал, байгууллага
3. Холбоо барих утас и-мэйл хаяг
4. Оролцох хэлбэр зэргийг тодорхой заана.

Илтгэлийг Эрдэм шинжилгээний өгүүлэл бичлэгийн стандартыг <http://seas.num.edu.mn/dep/am/files> линкээр татаж авна уу.

Хурлын илтгэлүүдээр ISSN индекс бүхий сэтгүүлийн тусгай дугаар гаргана.

Мэдээлэл, лавлагаа авах, холбоо барих утас: 8569-4213, 9918-2806,
и-мэйл хаяг : ganbold@seas.num.edu.mn, batbileg@seas.num.edu.mn